

Орон зайн судалгаа, эдийн засгийн нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Авирмэд Нармандах

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
3.1. Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох цогц арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих;							
1	Аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагчид, олон улсын байгууллагын оролцоог өргөжүүлэх арга хэмжээг авна.	Хэрэгжилтийн явц, хувиар	-	-	Аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих, орон зайн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлын хүрээнд Азийн хөгжлийн банк (АХБ), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) зэрэг олон улсын донор байгууллагуудад төслийн санал боловсруулан хүргүүлж, хамтран техник туслалцааны төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд: Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх техник туслалцааны төслийн бэлтгэл ажлын хүрээнд хоёр тал 4 удаа уулзалт хийж, АХБ-ны төслийн баг Монгол Улсад ирж ажиллав. Уулзалтаар мэдээллийн сангийн бүтэц,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардагдах санхүүжилт (1.25 сая ам.доллар)-ийг танилцуулсан бөгөөд АХБ төслийг 1 сая ам.долларын санхүүжилтээр дэмжихээ илэрхийлж, эх үүсвэрийг баталгаажуулаад байна. Төслийг эхлүүлэхэд наад зах нь 6 сар шаардлагатайг мэдэгдсэн. ЕСБХБ-тай мөн техник тусалцааны төсөл хэрэгжүүлэх чиглэлээр уулзалт хийж, төслийн санал хүргүүлсэн. Мөн "Ухаалаг засаглал-2" төслийн хүрээнд Аж үйлдвэрийн мэдээллийн сангийн техник хангамжийн (сервер) санхүүжилт шийдвэрлүүлэх зорилгоор танилцуулга, төсөв боловсруулан төслийн зөвлөх Э.Цогбаярт хүргүүлсэн. Хавсралтаар боловсруулсан техникийн төслийн санал болон уулзалтуудын мэдээллийг оруулав. Хавсралт: 3 файл		
3.2. Аж үйлдвэрийн бодлого, төлөвлөлтийг орон зайн судалгаанд тулгуурлан тодорхойлж, бодлогын хэрэгжилтийг нэгдсэн зохион байгуулалт, удирдлага, арга зүйгээр хангах, орон зайн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх;							
2	"Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сангийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн	Боловсруулсан тогтоолын төслийн тоо	-	Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, танилцуулсан байна. /1 тогтоолын	"Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан"-гийн талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2025 оны 01/177 дугаартай албан бичгээр төрийн захиргааны төв	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	100%

	газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ			төсөл/	байгууллагуудаас санал авч нэгтгэн, 2025 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн Засгийн газрын 8 дугаар хуралдаанд хэлэлцүүлэн батлуулсан (2025 оны 76 дугаар тогтоол). Энэхүү тогтоол батлагдсанаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын суурь мэдээллийн сангуудад тулгуурлан мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, мөн төрийн захиргааны төв байгууллагуудтай мэдээлэл харилцан солилцох боломж бүрдсэн. Сайдын чиглэлийн дагуу "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан"-гийн суурь нь "Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан" болох тул тогтоолын төслийг "Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан" нэрээр боловсруулах шийдвэр гаргасан. Хавсралт: 2 файл		
3	Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, эрхлэн хөтлөх ажлын хэсэг байгуулж, холбогдох төрийн байгууллагын мэдээллийн сангийн уялдаа холбоог гаргаж,	Хэрэгжилтийн явц, хувиар	-	-	Аж үйлдвэрийн орон зайн төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, эрхлэн хөтлөх ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулсан. Тус ажлын хэсгийн гишүүд нь мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхтэй холбогдуулан шаардлагатай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

	хамтарч ажиллана.				мэдээллийг нэгдсэн системд оруулах, мөн өөрийн чиг үүргийн хүрээнд хариуцан хөтөлдөг мэдээллийн сантай уялдуулан ажиллах үүрэг хүлээнэ. Мөн гишүүдийг Газарзүйн мэдээллийн систем (ArcGIS)-ийн сургалтад хамруулж, салбар хооронд мэдээллийг хамтран ашиглах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиг үүрэгтэй байна. Иймд ArcGIS программ хангамжийг худалдан авахтай холбоотойгоор ажлын хэсгийг байгуулах асуудлыг түр хугацаанд хүлээлгийн байдалд шилжүүлээд байна. Хавсралт: 1 файл		
4	Аж үйлдвэрийн орон зайн мэдээллийн нэгдсэн сан хөгжүүлэхтэй холбогдуулан Газар зүй мэдээллийн системийн программын эрх, лиценз худалдаж авах, зөвлөх үйлчилгээ, программ хөгжүүлэлтийн ажлыг зохион байгуулна.	Хэрэгжилтийн явц, хувиар	-	-	Газарзүйн мэдээллийн системийн ArcGIS программын лиценз эзэмшигч АНУ-ын Esri компанийн Монгол дахь албан ёсны төлөөлөгч “Монмап” ХХК-тай хамтран уулзалтууд зохион байгуулж, үнийн санал, зөвлөх үйлчилгээ болон программ хөгжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулсан. Тус программын санхүүжилтийг Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төслийн хүрээнд шийдвэрлүүлэхээр хамтын ажиллагааг эхлүүлээд байна. ArcGIS программын нэвтрүүлэлтийн төлөвлөгөө, зөвлөх үйлчилгээ болон сургалтын хуваарийг хавсаргав.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					Хавсралт: 3 файл		
5	Орон зайн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн системийг эрхлэн хөтлөх боловсон хүчнийг чадавхжуулах сургалт зохион байгуулах, олон улсын туршлага судална.	Хэрэгжилтийн явц, хувиар	-	-	Америкийн Нэгдсэн Улсын Esri компаниас Калифорни мужийн Палм Спрингс хотноо 2025 оны 3-р сарын 10-17-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Технологийн Дээд хэмжээний уулзалт, (Esri Developer & Technology Summit) сургалтад хамрагдсан. Сургалтаар ArcGIS систем, түүний архитектур, үндсэн боломжуудыг танилцуулсан бөгөөд энэ үеэр Esri-ийн мэргэжилтнүүд болон шилдэг хөгжүүлэгчидтэй уулзаж, ArcGIS-ийн дэвшилтэт шийдэл, аппликейшн, үйлчилгээг хөгжүүлэх шинэлэг стратеги, арга техникийг суралцсан. Мөн архитектурын гүйцэтгэл, уян хатан байдал, аюулгүй байдлыг судалж, түүний чадавхыг хэрхэн автоматжуулах, нэгтгэх, өргөтгөх, хянах талаар олж мэдсэн. Esri компанийн хөгжүүлэгчид болон удирдлагууд, Монгол дахь албан ёсны төлөөлөгч Монмап ХХК-тай хамтарсан гурван талын уулзалтыг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр хийж, мэдээллийн сангийн талаар санал солилцсон. Уулзалтын үр дүнд Esri компанийн зүгээс системийг нэвтрүүлэх ажилд дэмжлэг үзүүлэхээ илэрхийлж, Газарзүй мэдээллийн систем	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					ArcGIS программыг 4 дүгээр сард багтаан нэвтрүүлэлтийн ажлаа эхэлбэл нийт 582,3 сая төгрөгийн төсөвтэй ArcGIS Enterprise серверт мэдээлэл оруулах basic эрх (ArcGIS Enterprise GIS Professional Basic User Type Prepetual Subscription) 50 ширхгийг үнэгүй авахаар тохирсон болно.		
6	Хүнд, хөнгөн, боловсруулах үйлдвэрийн эдийн засгийн нөөцийн хөгжил байршлын судалгаа хийнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	-	-	Уг судалгааны ажлыг улсын болон урсгал төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2025 оны нэгдсэн төлөвлөгөөний төсөлд тусгасан боловч санхүүжилтийн боломжгүй шалтгаанаар хасагдсан. Удирдлагын өгсөн чиглэлийн дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/21 дүгээр тушаалаар батлагдсан улсын болон урсгал төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд ЭЗХЯ/20250203008 дугаартай “Аж үйлдвэрийн орон зайн мэдээллийн нэгдсэн санг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн мэдээллийн нэгдсэн сантай уялдуулах, сайжруулах чиглэлээр судалгаа хийх, системийн шаардлага боловсруулах” ажил болгон өөрчлөн тусгасан. Дээрх судалгааны ажлыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/135	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					дугаар тушаалаар Үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан. Үнэлгээний хорооны шийдвэрийг үндэслэн захиалагчид хүргүүлэх зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргаар баталгаажуулж, гэрээ байгуулах эрхийг олгох тухай 03/1546 дугаартай албан бичгийг хамгийн сайн үнэлэгдсэн тендерийн оролцогчид хүргүүлэн, гэрээ байгуулах шатанд ажиллаж байна. Хавсралт: 1 файл	
--	--	--	--	--	---	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Өөрийн хариуцсан чиг үүргийн хүрээнд сургалт, семинар,	Сургалтад хамрагдсан байх.	-	сургалт, семинар, хэлэлцүүлэгт оролцсон	- Америкийн Нэгдсэн Улсын Esri компаниас Калифорния мужийн Палм Спрингс хотноо 2025 оны 3-р сарын 10-17-ны өдрүүдэд	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р	100%


	хэлэлцүүлэгт оролцсон байх.			байна.	зохион байгуулагдсан Технологийн Дээд Хэмжээний Уулзалт (Esri Developer & Technology Summit) сургалтад хамрагдсан. -Худалдан авах ажиллагааны АЗ сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 3,4-ний өдрүүдэд хамрагдсан. Хавсралт: 1 файл	сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
2	Яамнаас зохион байгуулсан мэдээллийн цагт тогтмол хамрагдах	Мэдээллийн цагт хамрагдсан байх.Мэдээллийн цагт хамрагдсан байх.	-	-	2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын газраас зохион байгуулсан “Үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоо ба стратеги” сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан. 2025 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийг үндэслэн зохион байгуулсан гамшгаас хамгаалах сургалтад хамрагдсан. 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр “Олон ишт ба ёс зүйн эдийн засаг: Антропологийн чиг хандлага” сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан. 2025 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Макро эдийн засгийн бодлогын газраас зохион байгуулсан “Байгууллагын соёл ба ээлтэй орчин бүрдүүлэх” сэдэвт мэдээллийн цагт хамрагдсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАНИЛЦСАН

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Т.Баясгалан

/...../

Огноо:



ТАЙЛАН ГАРГАСАН:

Орон зайн судалгаа, эдийн засгийн нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Авирмэд Нармандах

/.....А. Нармандах...../

Огноо:2025.06.25.....